



ТӨВ АЙМГИЙН  
ЗУУНМОД СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 4/91

Зуунмод

Шар усны үер болон объектын гал түймрээс  
урьдчилан сэргийлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.18, 59 дүгээр зүйлийн 59.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаал “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, Шадар сайдын 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн “Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж”-ыг тус тус үндсэлэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд цаг агаарын дулааралтай холбоотойгоор шар усны үер, гал түймэр, мал амьтны гоц халдварт өвчний эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдлыг ханггуулж ажиллахыг сумын Захирагчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн (С.Мөнх-Амгалан)-д, үерийн хамгаалалтын барилга байгууламж, зам талбайн ус зайлуулах зориулалтын инженерийн байгууламж, үерийн далан, гуу жалга, айл өрхийн арын цасыг түрж зайлуулах ажлыг “Төв АЗЗА” ТӨХК-ийн дарга (Д.Болдбаатар), Хот тохижуулах газрын дарга (А.Шаравнямуу), багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2. Сумын нутаг дэвсгэрт малын өтгө бууц, мал амьтны сэг зэмийг төвлөрсөн хогийн цэгт 2023 оны 03 дугаар сарын 15-наас 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд үнэ төлбөргүй буулгах ажлыг Хот тохижуулах газрын дарга (А.Шаравнямбуу)-д, ариутгал халдвартгүйжүүлэлтийн ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Тархвар зүйч (Э.Долгормаа), Байгаль орчны мэргэжилтэн (О.Одням), багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Хаврын хуурайшилтын улирал эхэлж байгаатай холбогдуулан объектын гал түймрийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үзлэг шалгалтыг зохион байгуулж ажиллахыг Зуунмод сум дахь Гал түймэр унтраах, аврах 24 дүгээр ангийн захирагч, ахмад (Д.Бадамсамбуу), урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, сээрэмжлүүлгийг шторк хэлбэрээр

dd

бэлтгэн олон нийтэд сурталчилж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын Интернэт хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажилтан (Г.Уянга)-д тус тус үүрэг болгосугай.

4.Шар усны үер болон объектын гал түймэр, мал амьтны гоц халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх ажилд шаардагдах 1.100.000 /Нэг сая нэг зуун мянган/ төгрөгийг сумын Засаг даргын нөөц сангаас гаргахыг сумын Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (С.Намшир)-т зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг нэгдсэн удирдлагаар хангаж, шаардлагатай тохиолдолд хүн хүч, техник хэрэгслийг дайчлан гаргах арга хэмжээг авч ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Н.Энхсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА БОГОӨД ОНЦГОЙ  
КОМИССЫН ДАРГА

ЧАРАНГЭРЭЛ

